



**НИЙСЛЭЛИЙН
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар A/25

Улаанбаатар хот

**Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.6, 9.3 дахь заалт, Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.3 дахь зүйл, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 13 дугаар зүйлийн 13.1.1, 4.1.10 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 1,2,3 дугаар паркуудын гадаад, дотоод орчинд утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад ажлын орчинд тамхи татахыг хориглосугай.

2. Байгууллагын орох хаалга, хүлээлгийн танхим, хонгил, бие засах газар, авто засварын өрөө, манаачийн байр, бүх паркуудын гарааш, диспетчерийн өрөөнүүд, бусад шаардлагатай газарт тамхи татахыг хориглосон анхааруулах болон зөвшөөрсөн тэмдэг, тэмдэглэгээг 03 дугаар сарын 16-ноос 03 дугаар сарын 18-ныг дуустал хугацаанд байрлуулан ажиллахыг Тээвэр зохицуулалтын хэлтэс/ Х.Ажрахгүй/-т, даалгасугай.

3. Уг тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг диспетчер-механикуудад, хяналт тавьж ажиллахыг бүх хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалтай холбогдох зардлыг тооцож гаргахыг Санхүү, төлөвлөлтийн хэлтэс/ Х.Одончимэг/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ш.НАРАНБААТАР